

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 09 сарын 27 өдөр

Дугаар 1/43

Өлгий

Г  
Т  
Шинээр байгуулагдах өрхийн эрүүл мэндийн  
төвүүдийг сонгон шалгаруулах үнэлгээний  
хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Эмнэлгийн тусlamж үйлчилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь заалт, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46, 47 дугаар зүйл, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/367 дүгээр Өрхийн Эрүүл мэндийн төвийг сонгон шалгаруулах журам шинэчлэн батлах тухай тушаал Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/104 дүгээр “Журам, гэрээний загвар шалгуур үзүүлэлт батлах тухай” 4 дүгээр зүйлийн 4.11, 4.12 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 5.3.4 дэх хэсэг, 5.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2022 оны А/391 дүгээр захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн дүгнэлтээр 2 удаа “Хангалтгүй” дүгнэгдсэн Өлгий сумын 2, 3, 12, 13 дугаар багуудын иргэдэд Эрүүл мэндийн анхан шатны тусlamж үзүүлж буй Мэйрим ӨЭМТөв болон 1, 8 дугаар багийн ард иргэдэд Эрүүл мэндийн анхан шатны тусlamж үйлчилгээ үзүүлж буй Раушан ӨЭМТөвтэй байгуулсан гүйцэтгэлийн гэрээг цуцалсан тул Өлгий сумын 1, 8-р багууд болон 2, 3, 12, 13 дугаар багуудад байгуулагдах Өрхийн Эрүүл мэндийн төвийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Шинээр байгуулагдах Өрхийн Эрүүл мэндийн төвийг сонгон шалгаруулах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг үнэлгээний хорооны дарга Эм, эмнэлгийн хэрэгсэл хангамж хариуцсан мэргэжилтэн /Т.Нурсауле/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Н.САКЕН



Эрүүл мэндийн газрын даргын  
2023...оны 09...сарын 27...өдрийн 11:43...тоот  
тушаалын Индумурж хавсралт

БЮЕ0019

## ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ГИШҮҮД

Үнэлгээний хорооны дарга -

Эм, эмнэлгийн хэрэгслийн  
хангамж, тусгай зөвшөөрөл  
хариуцсан мэргэжилтэн  
Т.Нурсауле

Гишүүд -

Өлгий сумын ЗДТГ-ын төсөв,  
төрийн сангийн мэргэжилтэн  
Т.Алмасбек

ОНӨГ-ын худалдан авалт  
хариуцсан мэргэжилтэн  
А.Багдат

Эрүүл мэндийн газрын Бичиг  
хэрэг, ХАБ-ын ажилтан  
А.Сунхар

Эрүүл мэндийн газрын  
Эмнэлгийн тоног төхөөрөмж,  
засвар үйлчилгээ хариуцсан  
ажилтан С.Бекет

Өлгий сумын 1-р багийн  
иргэний төлөөлөл Б.Тажибек

Өлгий сумын 1-р багийн  
иргэний төлөөлөл Б.Нурболат

Өлгий сумын 2-р багийн иргэн  
Ш.Жанимхан

Нарийн бичгийн дарга-

Анхан шатны тусlamж  
үйлчилгээ хариуцсан  
мэргэжилтэн Ж.Нурбота

Эрүүл мэндийн газрын даргын  
2023. оны 09 сарын 27 өдрийн 14:45 тоот  
тушаалын хөгжлийн хавсралт



## ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг: Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журам нь хот, суурин газрын хун амд өрхийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгэх өрхийн эрүүл мэндийн төвийн багийг (цаашид баг гэх) сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохицуулахад чиглэгдэнэ
- 1.2 Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тухай хууль, Нөхөрлөлийн тухай хууль, Компаний тухай хуулийг үндэслэн аймгийн Эрүүл мэндийн газар өрхийн эрүүл мэндийн төвийг шинээр эсхүүл ажиллаж буй өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн гэрээ цуцлагдсан тохиолдолд өрхийн эрүүл мэндийн төвийг нөхөн сонгон шалгаруулахад энэхүү журмыг баримтална.

Хоёр: Сонгон шалгаруулах ажлын зохион байгуулалт

1. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/104 дүгээр тушаалын дагуу өрхийн эрүүл мэндийн төвүүдэд хяналт үнэлгээ хийхэд хангалтгүй үнэлэгдэж татан буугдсан өрхийн эрүүл мэндийн төвүүдийн оронд 1, 8, 2, 3, 12, 13 дугаар багуудад Өрхийн Эрүүл мэндийн төв шинээр байгуулах

- 2.1 Аймгийн Эрүүл мэндийн газрын даргын тушаал байгуулагдсан үнэлгээний хороо сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулна.
- 2.2 Сонгон шалгаруулах үйл ажиллагааг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” болон холбогдох бусад хуулийн дагуу зохион байгуулна
- 2.3 Сонгон шалгаруулалт хийх үнэлгээний хороо нь 9-өөс доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд тус хорооны бүрэлдэхүүнд тухайн үйлчлэх хүрээний хүн амын төлөөлөл болон Эрүүл мэндийн газрын анхан шатны тусlamж, үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн заавал байна.
- 2.4 Сонгон шалгаруулалт нь ил тод, нээлттэй, шударга байх зарчмыг баримтална.
- 2.5 Шаардлага хангасан баг нь сонгон шалгаруулалтад оролцох бүрэн эрхтэй.
- 2.6 Сонгон шалгаруулалттай холбоотой гарсан аливаа гомдол, маргааныг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ
- 2.7 Сонгон шалгаруулалтад тэнцсэн багтай хуулийн хугацаанд гэрээ байгуулж ажиллана

Гурав. Сонгон шалгаруулалтад оролцох багт тавигдах шаардлага

- 3.1 Сонгон шалгаруулалтад оролцох баг нь нөхөрлөл хэлбэрээр байгуулагдсан бол “Нөхөрлөлийн тухай”, компани хэлбэрээр байгуулагдсан бол “Компаний тухай” хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, хуулийн этгээд байна.
- 3.2 Баг нь өрхийн эрүүл мэндийн төвийн дүрэмд зааснаар төвийн даргыг томилж, сонгон шалгаруулалтад оролцуулна.
- 3.3 Баг нь өрхийн эрүүл мэндийн төвд үзүүлэх тусlamж, үйлчилгээний

жагсаалтын дагуу эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ үзүүлэх чадавхитай байна.

3.4 Баг нь өрхийн эрүүл мэндийн төвийн хөгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөөтэй байна. Төлөвлөгөөнд дараах асуудлыг тусгасан байна. Үүнд:

3.4.1 Стратегийн зорилго, зорилтыг тодорхойлсон байх,

3.4.2 Байгууллагын эрхэм зорилго, хүн амын хамрах хүрээ, үйлчлэх хүн амын эрүүл мэндийн байдалд үнэлгээ, дүгнэлт өгч, үйл ажиллагааны зорилтот түвшин, түүнд хүрэх үйл явц, цогц арга хэмжээг тодорхойлсон байх,

3.4.3 Үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж хүртээмж, тасралтгүй байдал, чанарыг сайжруулах, үйлчилгээний чадавхийг дээшлүүлэх арга замыг тодорхойлсон, тэдгээрийг практикт нэвтрэх үйл ажиллагааг төлөвлөсөн байх,

3.4.4 Байгууллагын үйл ажиллагааг мэдээллийн технологи, маркетинг, санхүүгийн удирдлагад суурilan удирдан явуулахаар төлөвлөсөн байх,

3.4.5 Төвийн хүний нөөцийг хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлсон байх,

3.4.6 Өрхийн эрүүл мэндийн төвийн тусlamж, үйлчилгээний чанарын хөтөлбөрийг боловсруулж, чанарыг сайжруулах, үр дүнг дээшлүүлэх арга замыг тодорхойлж, магадлан итгэмжлэлд хамрагдах асуудлыг тусгасан байх,

3.4.7 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдөж, мэргэжлийн үүргийг чанд биелүүлж, хамт олон баг бүрдүүлж ажиллахыг тодорхойлсон байх.

3.5 Баг нь өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандартаар баталсан хүний нөөцийг бүрдүүлсэн байна. Үүнд:

3.5.1 Эмч, эмнэлгийн мэргэжилтэн нь эмчлэх, сувилах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх, давхар ажил эрхлэдэггүй, ашиг сонирхолын зөрчилгүй байх,

3.5.2 Нийгмийн эрүүл мэндийн ажилтан нь нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр суралцаж, мэргэшсэн, нийгмийн эрүүл мэндийн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байсан туршлагатай байх эсвэл нийгмийн эрүүл мэндийн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлсэн туршлагатай эмч, сувилагч байж болно,

3.5.3 Сонгон шалгаруулалтад орох багийн гишүүн өмнө нь гэрээ цуцлагдсан өрхийн эрүүл мэндийн төвийн багийн гишүүнээр ажиллаж байсан байж болох бөгөөд мэргэжпийн болон ёс зүйн зөрчил гаргаагүй байх,

3.5.4 Сонгон шалгаруулалтад орох багийн гишүүд өмнө нь гэрээ цуцлагдсан өрхийн эрүүл мэндийн төвийн багийн гишүүнээр ажиллаж байсан тохиолдолд багийн бүрэлдэхүүний 60%-иас ихгүй байх.

3.6. Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтэй баг нь дараах баримт бичгийг бүрдүүлж сонгон шалгаруулалтад оролцоно. Үүнд:

3.6.1 Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт бүхий албан тоот,

3.6.2 Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, нотариатаар баталгаажуулсан байх,

3.6.3 Багийн гишүүдийн хурлын тэмдэглэл, эх хувиар,

- 3.6.4      Өрхийн эрүүл мэндийн төвийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөөний төсөл
- 3.6.5      Ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтний эмчлэх, сувилах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хуулбар,
- 3.6.6      Баг нь өрхийн эрүүл мэндийн төвд үзүүлэх тусlamж, үйлчилгээний жагсаалтын дагуу эрүүл мэндийн тусlamж үзүүлэх чадавхтайг гэрчилсэн шаардлагатай баримт бичгүүд,
- 3.6.7      Сонгон шалгаруулалтад оролцох баг нь давхар өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа эрхэлдэггүй байх, зээл, өр авлагагүйг илэрхийлэх баримт, нотолгоог хавсаргасан байх,
- 3.6.8      “Төрийн болон орон нутгийн емчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах” тухай хуульд заасан бусад баримт бичгүүд.
- 3.6.9      Сонгон шалгаруулалтад бүрдүүлсэн материалын үнэн бодит эсэхийг тухайн багийн дарга нь хариуцах бөгөөд хуурамч баримт бүрдүүлсэн тохиолдолд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.